

Сангийн сайдын 2017 оны  
361 дугаар тушаалын  
3 дугаар хавсралт

Регистрийн дугаар 

2	6	8	8	3	5	2
---	---	---	---	---	---	---

Хаяг: БГД 20-р хороо





Шуудангийн хаяг:

Утас: 7000-1374

Факс: 7018-1819

Өмчийн хэлбэр: Төрийн 100 хувь

## "ДЦС - 4" ТӨХК-ИЙН 2020 ОНЫ 2-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг
Сангийн яам		
Эрчим хүчний яам	21/21	
ТӨБЗГазар	21/21	
Эрчим хүчний зохицуулах хороо	21/21	
Хөрөнгийн бирж	21/21	
Санхүүгийн зохицуулах хороо		

серт

**"ДЦС - 4" ТӨХК-ний  
2020 оны 2-р улирлын санхүүгийн тайлангийн  
бодит байдлын тухай мэдэгдэл**


2020 оны 07 сарын 20 өдөр

Гүйцэтгэх Захирал **Ү.Төмөрхуяг**, ерөнхий нягтлан бодогч **Д.Төмөртогтоо** бид манай аж ахуйн нэгжийн 2020 оны 06 сарын 30-ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 17.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан;
2. Санхүүгийн тайланд тусгасан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн;
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан;
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй;
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан;
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Гүйцэтгэх Захирал.....  /Ү.Төмөрхуяг/

Ерөнхий ня-бо.....  /Д.Төмөртогтоо/



## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**ДЦС - 4 ТӨХК**

2020 оны 06 сарын 30 өдөр

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2020 оны 01-р сарын 01-ны өдөр	2020 оны 06-р сарын 30-ны өдөр
А	Б	1	2
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	592,455,956.46	5,332,709,780.32
1.1.2	Дансны авлага	18,167,341,613.85	23,214,858,713.03
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	457,180,919.30	467,005,953.73
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	19,034,265,111.29	21,352,434,317.13
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	1,938,029,854.16	5,984,540,712.32
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө /борлуулах бүлэг		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>40,189,273,455.06</b>	<b>56,351,549,476.53</b>
<b>1.2</b>	<b>Эргэлийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	671,580,266,080.11	652,555,873,199.93
1.2.2	Биет бус хөрөнгө	47,949,030,132.78	47,617,220,160.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	173,881,374,941.54	240,106,534,957.47
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>893,410,671,154.43</b>	<b>940,279,628,317.40</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>933,599,944,609.49</b>	<b>996,631,177,793.93</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	11,601,030,912.00	5,454,352,163.40
2.1.1.2	Цалингийн өглөг	3,997,099,172.00	
2.1.1.3	Татварын өр	6,872,978,530.22	9,922,619.77
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	18,778,297,253.26	29,388,553,491.82
2.1.1.6	Хүүний өглөг	3,158,960,647.33	6,652,076,518.22
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	5,112,746,557.18	5,113,168,151.95
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	736,400,743.81	726,562,861.40
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,677,134,942.62	162,842,176.51
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө /борлуулах бүлэг		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>51,934,648,758.42</b>	<b>47,507,477,983.07</b>

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 01-р сарын 01-ны өдөр	2020 оны 06-р сарын 30-ны өдөр
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	269,184,405,979.69	332,778,540,378.14
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	7,253,117,956.77	9,324,268,162.42
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	12,568,608,574.24	12,568,608,574.24
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5	Хойшлогдсон орлого	116,232,148,269.24	113,693,599,226.54
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>405,238,280,779.94</b>	<b>468,365,016,341.34</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>457,172,929,538.36</b>	<b>515,872,494,324.41</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	а) төрийн	107,919,748,900.04	107,919,748,900.04
2.3.2	Өмч	б) хувийн	
2.3.3		в) хувьцаат	
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	312,961,118,390.38	312,961,118,390.38
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	48,769,166,973.00	48,769,166,973.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	6,776,980,807.71	11,108,649,206.10
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>476,427,015,071.13</b>	<b>480,758,683,469.52</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>933,599,944,609.49</b>	<b>996,631,177,793.93</b>

Гүйцэтгэх Захирал ..... /Төмөрхуяг/

Ерөнхий нягтлан бодогч ..... /Д.Төмөртоогоо/



## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

**ДЦС - 4 ТӨХК**

2020 оны 06 сарын 30 өдөр

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 06 сарын 30	2020 оны 06 сарын 30
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого /цэвэр/</b>	<b>128,325,722,602.03</b>	<b>153,372,118,949.34</b>
2	Борлуулалтын өртөг	114,835,816,899.77	135,348,533,124.74
<b>3</b>	<b>Нийт ашиг /алдагдал/</b>	<b>13,489,905,702.26</b>	<b>18,023,585,824.60</b>
4	Түрээсийн орлого	124,374,325.76	85,444,140.00
5	Хүүний орлого	117,022,257.65	69,772,108.67
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	3,346,521,161.98	3,832,818,651.93
9	Борлуулалт, маркетингийн зардал	515,587,078.09	1,210,455,997.09
10	Ерөнхий удирдлагын зардал	907,158,953.99	1,422,649,675.78
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	1,646,667,827.88	1,041,723,914.89
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	-264,485,427.93	-11,957,240,169.88
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/		
17	Бусад ашиг /алдагдал/		
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>13,743,924,159.76</b>	<b>6,379,550,967.56</b>
19	Орлогын татварын зардал	11,702,225.77	6,977,210.88
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>	<b>13,732,221,933.99</b>	<b>6,372,573,756.68</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>13,732,221,933.99</b>	<b>6,372,573,756.68</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз /гарз/		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>		
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/</b>		

Гүйцэтгэх Захирал .....  /Y. Temerkhuyag/

Ерөнхий нягтлан бодогч .....  /D. Temertogoo/



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2020 оны 06 сарын 30 өдөр

ДЦС - 4 ТӨХК

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

/Төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	107,919,748,900.04			254,003,946,545.24			-39,751,372,689.63	322,172,322,755.65
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-7,627,225,146.07	-7,627,225,146.07
3	Залруулсан үлдэгдэл								
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/							880,082,913.41	880,082,913.41
5	Бусад дэлгэрэнгүй орлого								0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт								0.00
7	Зарласан ногдол ашиг								0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				58,957,171,845.14		48,769,166,973.00	53,275,495,730.00	161,001,834,548.14
9	2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	107,919,748,900.04			312,961,118,390.38		48,769,166,973.00	6,776,980,807.71	476,427,015,071.13
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-2,040,905,358.29	-2,040,905,358.29
11	Залруулсан үлдэгдэл								0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/							6,372,573,756.68	6,372,573,756.68
13	Бусад дэлгэрэнгүй орлого								0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт								0.00
15	Зарласан ногдол ашиг								0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								0.00
17	2020 оны 06-р сарын 30-ны үлдэгдэл	107,919,748,900.04	0.00	0.00	312,961,118,390.38	0.00	48,769,166,973.00	11,108,649,206.10	480,758,683,469.52

Гүйцэтгэх Захирал

Д.Төмөртуяаг /Д.Төмөртоогоо/



Ерөнхий нягтлан бодогч

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ДЦС-4 ТӨХК

2020 оны 06 сарын 30 өдөр


(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 06 сарын 30	2020 оны 06 сарын 30
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн /+/	<b>129,059,888,923.95</b>	<b>143,169,432,027.54</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	128,096,465,914.10	138,555,669,608.06
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	963,423,009.85	4,613,762,419.48
1.2	Мөнгөн зарлагын дүн /-/	<b>121,564,508,805.40</b>	<b>133,956,715,098.96</b>
	Ажиллагчдад төлсөн	19,369,316,224.00	21,407,679,916.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,320,740,274.29	5,680,000,000.00
	Бараа материал худалдан авахад	54,300,191,445.00	57,918,029,208.00
	Ашиглалтын зардалд төлсөн		
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	25,954,084,676.14	25,215,710,452.03
	Хүүний төлбөрт төлсөн		3,788,018,902.57
	Татварын байгууллагад төлсөн	9,144,456,074.86	15,968,756,812.88
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	7,475,720,111.11	3,978,519,807.48
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>7,495,380,118.55</b>	<b>9,212,716,928.58</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн /+/	<b>56,803,940.32</b>	<b>69,772,108.67</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого		
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	56,803,940.32	69,772,108.67
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн /-/	<b>50,377,026,358.79</b>	<b>7,031,536,853.05</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,938,486,865.68	2,083,410,680.98
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	48,438,539,493.11	4,948,126,172.07
	Бусад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>-50,320,222,418.47</b>	<b>-6,961,764,744.38</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн /+/	<b>53,525,610,380.19</b>	<b>4,948,126,172.07</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	53,525,610,380.19	4,948,126,172.07
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн /-/	<b>7,143,609,219.11</b>	<b>2,458,824,532.41</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	7,143,609,219.11	2,458,824,532.41
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>46,382,001,161.08</b>	<b>2,489,301,639.66</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<b>3,557,158,861.16</b>	<b>4,740,253,823.86</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,538,043.30	592,455,956.46
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,012,542,904.46	5,332,709,780.32

Гүйцэтгэх Захирал ..... /У.Төмөрхуяг/

Ерөнхий нягтлан бодогч ..... /Д.Төмөртоогоо/



**“ДЦС-4” ТӨХК-ИЙН 2020 ОНЫ 2-Р УЛИРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН  
ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ,  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА**

**Техник эдийн засгийн үзүүлэлтийн талаар**

2020 оны эхний хагас жилд 2,033.9 сая кВтц цахилгаан эрчим хүч боловсруулан дотоод хэрэгцээнд 12.25% буюу 249.1 сая кВтц цахилгаан эрчим хүч хэрэглэж 1,784.8 сая кВтц цахилгаан эрчим хүч түгээхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,050.1 сая кВтц цахилгаан эрчим хүч боловсруулан дотоод хэрэгцээнд 11.86% буюу 243.1 сая кВтц цахилгаан эрчим хүч хэрэглэж 1,807.0 сая кВтц цахилгаан эрчим хүч түгээснээр цахилгаан эрчим хүчний түгээлтийн төлөвлөгөөг 101.2%-аар биелүүлсэн.

Техник эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл: Боловсруулсан цахилгаан эрчим хүч 60.8 сая кВтц, түгээсэн цахилгаан эрчим хүч 61.8 сая кВтц-аар тус тус нэмэгдсэн байна. “ДҮТ” ХХК-д 1,784.8 сая кВтц ЦЭХ худалдсан нь өмнөх оноос 56.9 сая кВтц-аар өссөн байна.

Тайлант хугацаанд 2,096.1 мянган Гкал дулааны эрчим хүч түгээхээр төлөвлөснөөс 2,094.1 мянган Гкал дулааны эрчим хүч түгээж дулааны эрчим хүчний төлөвлөгөөг 99.9%-иар биелүүлж, төлөвлөснөөс 1.9 мянган Гкал-аар буурч, өмнөх оны мөн үеэс 48.9 мянган Гкал-аар өссөн байна. Усаар 1,964.9 мянган Гкал, уураар 129.1 мянган Гкал түгээж, төлөвлөснөөс усаар 7.0 мянган Гкал-аар тасарч, уураар 5.1 мянган Гкал-аар өссөн байна.

Диспетчерийн графикийн биелэлтийг ЦЭХ-нд 102.5%, ДЭХ-нд 100% биелүүлж ажиллалаа. СПОТ арилжааны зах зээлд 1,066.1 мянган кВтц цахилгаан эрчим хүч худалдаж, 816.2 мянган кВтц цахилгаан эрчим хүч худалдан авсан ба арилжаанаас 45.6 сая төгрөгийн авлагатай ажиллалаа.

Тайлант хугацаанд 8 зуух, 7 турбоагрегатын горимд ажиллалаа. Эхний хагас жилийн байдлаар 5.55 зуух, 5.44 турбинтэй ажиллаж, нэг зуух бэлтгэлд, бэлтгэл турбингүй ажилласан. Тайлант хугацаанд зуухыг 29 удаа, турбиныг 25 удаа тус тус зогссон. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал зуухны зогсолт 2-оор турбины зогсолт 1-ээр буурсан байна.

Өмнөх оны мөн үед нийт боловсруулсан цахилгаан эрчим хүчний 12.27%-ийг дотоод хэрэгцээнд зарцуулж байсан бол тайлант хугацаанд 11.86%-ийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 0.41 нэгжээр, төлөвлөгөөнөөс 0.39 нэгжээр буурсан.

Жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаанд 275.86 гр/кВтц, дулаанд 171.39 кг/Гкал байгаа нь төлөвлөгөөтэй харьцуулахад цахилгаанд 4.69 гр/кВтц-аар, дулаанд 0.68 кг/Гкал-аар, өмнөх оны мөн үеэс цахилгаанд 4.14 гр/кВтц-аар, дулаанд 1.24 кг/Гкал-аар тус тус буурсан байна. Тайлант хугацаанд 857,400.0 тжт зарцуулсан нь төлөвлөгөөтэй харьцуулахад 4,000.8 тжт хэмнэсэн байна.

Үндсэн гол параметруудийг төлөвлөсөн хэмжээнд барьж ажилласан нь түлш хэмнэхэд сайн нөлөө үзүүлсэн байна.



Горим ажиллагаанаас хэмнэсэн жишмэл түлшний хэмнэлт, хэтрэлтийн тооцоо:

№	Үзүүлэлт	Хэтрэлт/ хэмнэлт (тжт)
1	Тэжээлийн усны халуун	-3,817
2	Турбины вакуум	-4,917
3	Уур усны алдагдал	-1,515
4	ДХЦЭХ	-6,113
5	Хослон үйлдвэрлэлийн хэмжээ хасагдсанаас /+/ Зуухны халуун, хүйтэн галлагаа	10,380 401
6	Утааны хийн халуун	341
7	Уурын хувийн зарцуулалт төлөвлөснөөс өссөн /+/ <b>БҮГД</b>	3,695 <b>-8,934</b>

Тайлант хугацаанд 8,934 тонн жишмэл түлш буюу 3,349 ккал/кг илчлэгтэй 18,692 тонн нүүрс хэмнэсэн.

Тайлант хугацаанд 620 тн мазут зарцуулахаас 461 тн-ыг зарцуулж 159 тн мазутыг хэмнэж ажиллалаа.

“ДҮТ” ХХК-ийн диспетчерээс 384 удаа нэмэх, 159 удаа хасах шийдвэр өгөгдөж 285-792 МВт-ын хооронд ачааллыг зохицуулан ажиллалаа. Үйлдвэрлэлийн явцад ажиллагаанд байгаа тоноглолын тоо тэдгээрийн хүчин чадал ашиглалтын хувь, түлж буй нүүрсний төрөл чанар гэх мэт хүчин зүйлээс хамаарч горим хэлбэлзэлтэй байдаг бөгөөд тайлант хугацаанд ашигтай горимоор ажилласан гэж үзэж байна.

Станцын дотоод циклийг нөхөх уур усны алдагдлыг төлөвлөгөөнөөс 1.0 нэгж хувиар бууруулж 94.4 мянган тонн конденсат хэмнэсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны хэмжээ 36.4 мянган тонноор буурсан байна. Тайлант хугацаанд дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр зууханд 2,938 м<sup>3</sup> ус, турбинд 97,664 м<sup>3</sup> ус өгсөн байна.

### **Борлуулалтын орлогын талаар**

Компанийн хэрэглэгчдэд борлуулах үнэ тарифыг ЭХЗХ-ны 2020 оны 1 дүгээр сарын 30-ний өдрийн 24 тоот тогтоолоор батлагдсан тарифыг мөрдөж ажилласан:

“ДҮТ” ХХК-д худалдах тариф:

Энергийн тарифыг	I-II улиралд	37.73 төг/кВтц,
Чадлын тарифыг	I улиралд	10,677,613.0 мян.төг/сар
	II улиралд	7,352,987.0 мян.төг/сар

“УБДС” ТӨХК-д худалдах дулааны тарифыг:

I улиралд	12,003.56 төг/Гкал-р
II улиралд	14,117.89 төг/Гкал-р

Шууд борлуулах тарифыг:

Цахилгаанд:

I-II улиралд:	ААН-д худалдах тарифыг 140.59 төг/кВтц,
	Дэмжих тарифыг 23.79 төг/кВтц,
	Чадлын тарифыг 9,000.0 төг,

Дулаанд:

УБ хотын ҮААН-д борлуулах дулааны уурын тарифыг:

I-II улиралд: 22,600.0 төг/Гкал-аар  
 ААН-д худалдах дулаан усаар:  
 I-II улиралд: 30,461.2 төг/Гкал  
 Баянголын амны дулааныг ОСНААУГ-т борлуулах тариф:  
 1-4-р сард: 13,250.00 төг/Гкал  
 5 дугаар сарын 1-нээс: 15,137.38 төг/Гкал

Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанаас 151,565.4 сая төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөснөөс 153,372.1 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөөг 101.2%-иар буюу 1,806.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулалтын орлого 13,589.4 сая төгрөгөөр өссөнөөс ЦЭХ-ний орлого 11,981.6 сая төгрөгөөр ДЭХ-ний орлого 1,607.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Үндсэн бус үйл ажиллагаанаас 4,100.6 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Нийт 157,472.7 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөөг 1,519.9 сая төгрөгөөр буюу 101.0 хувиар давуулан биелүүлсэн.

*Орлогын төлөвлөгөөний биелэлтийг харуулбал*

сая төгрөг

Д/д	Орлогын төрөл	Төлөвлөгөө /НӨАТ-гүй/	Гүйцэтгэл /НӨАТ-гүй/	Өсөлт/ Бууралт
	<b>Нийт орлого</b>	<b>155,952.8</b>	<b>157,472.7</b>	<b>1,519.9</b>
1	ЦЭХ-ний орлого	123,651.2	125,817.5	2,166.3
2	ДЭХ-ний орлого	27,914.2	27,554.6	-359.6
	Үүнээс: Усаар орлого	25,728.3	25,375.5	-352.8
	Уурын түгээсэн орлого	2,185.9	2,179.1	6.8
3	Үйл ажиллагааны бус орлого	4,387.3	4,100.6	-286.8

Эрчим хүчний нийт борлуулалтын орлогын 79.3%-ийг “ДҮТ” ХХК-тай байгуулсан гэрээ болон төлбөр тооцооны дүнгээр авах орлого бүрдүүлж байгаа бөгөөд нийт орлого цуглуулалт 96.9%-тай байна.

“ДҮТ” ХХК, “УБДС” ТӨХК болон бусад хэрэглэгч компаниудтай байгуулсан бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ болон гэрээний биелэлтээр авах ёстой орлогын 12.7% нь хоорондын тооцоогоор, 87.2% нь харилцахаар, 0.1% нь кассаар орж ирсэн байна.

Худалдсан эрчим хүчний төлбөрийн биелэлтийг хүснэгтээр харуулбал:

сая төгрөг

№	Борлуулалт	Бичилтээр	Гүйцэтгэл	Хувиар	Зөрүү
1	“ДҮТ” ХХК	133,743.6	127,638.2	95.4%	-6,105.4
2	“УБДС” ТӨХК	26,487.7	27,583.8	104.1%	1,096.1
3	Уурын борлуулалт	2,396.9	2,364.1	98.6%	-32.8
4	Өөрийн борлуулалт ЦЭХ	495.2	491.6	99.3%	-3.6
5	Өөрийн борлуулалт ДЭХ	700.9	705.1	100.6%	4.2
6	СПОТ зах зээл	66.2	60.9	92.0%	-5.3
	<b>Дүн</b>	<b>163,890.5</b>	<b>158,843.7</b>	<b>96.9%</b>	<b>-5,046.8</b>

### Өртөг зардлын талаар

Тайлант хугацаанд бүтээгдэхүүний нэгжийн өөрийн өртгийг тооцон 1 кВтц цахилгаан эрчим хүчинд 51.34 төгрөг, 1 Гкал дулааны эрчим хүчинд 24,773.62 төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр цахилгаан 48.30 төгрөг, 1 Гкал дулаан 23,616.04 төгрөг болж өртөг цахилгаанд 3.04 төгрөг, дулаанд 1,157.58 төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант хугацаанд нийт 151,092.6 сая төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөснөөс 3,180.0 сая төгрөгөөр өссөн. Үндсэн үйл ажиллагаанд 135,487.0 сая төгрөг зарцуулж, төлөвлөснөөс 8,061.6 сая төгрөгөөр буурсан. Төлөвлөгөөтэй харьцуулахад хувьсах зардал 2,776.1 сая төгрөгөөр, тогтмол зардал 5,285.5 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна. Үйл ажиллагааны бус зардал 11,241.6 сая төгрөгөөр хэтэрсэн. Үйл ажиллагааны бус зардалд тусгагдсан 12,069.8 сая төгрөгийн валютын ханшийн бодит бус алдагдлыг хасаж тооцвол үйл ажиллагааны бус зардал 828.2 сая төгрөгөөр, нийт зардал 8,889.8 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Нийт зардалд түлшний зардал 47.6%, цалингийн зардал 13.8%, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 15.1%, бусад тогтмол зардал 13.2%, үйл ажиллагааны бус зардал 10.3%-ийг тус тус эзэлж байна.

Зардлын хэмнэсэн, хэтэрсэн шалтгааныг судалж үзэхэд:

- 1 Түлшний зардал 2,766.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Нүүрсний зарцуулалт төлөвлөгөөт хэмжээнээс 88,108.5 тонноор буурснаар 2,379.0 сая төгрөг, мазутын хэрэглээ 159 тонноор буурснаар 387.1 сая төгрөг тус тус хэмнэсэн.
- 2 Ашиглалтын цахилгаан эрчим хүчний зардал 869.6 сая төгрөгөөр хэтэрсэн нь түгээлт өссөнөөр трансформаторын алдагдлын хэмжээ 5.3 сая кВтц-аар нэмэгдэж зардлыг хэтрүүлсэн.
- 3 Ашиглалтын дулааны зардал 377.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь дотоод хэрэгцээний дулааны зардал төлөвлөгөөт хэмжээнээс 12.3 мянган Гкал-аар буурсантай холбоотой.
- 4 Гэмтэл устгал болон графикт урсгал засварын зардал 2,086.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь материалын нийлүүлэлтээс шалтгаалсан.
- 5 Хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал 349.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь материалын нийлүүлэлтээс шалтгаасан хэмнэлт юм.
- 6 Үйл ажиллагааны бус зардал 11,241.6 сая төгрөгөөр хэтэрсэн нь валютын ханшийн бодит бус алдагдалд 12,069.8 сая төгрөгийн зардал гарснаас нөлөөлсөн. Үүнийг тооцвол 828.2 сая төгрөгөөр үйл ажиллагааны бус зардал хэмнэгдсэн.
- 7 Мөн COVID-19 вирусээс шалтгаалан томилолт, сургалт, гадны үйлчилгээ, зар сурталчилгаа, тос шатахуун, гэх мэт зардлууд хэмнэгдсэн.

### **Ашиг алдагдлын талаар**

2020 оны эхний хагас жилд балансын дүнгээр 8,040.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 6,379.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллан, төлөвлөгөөнөөс 1,660.6 сая төгрөгөөр буурсан байна.

12,069.8 сая төгрөгийн валютын ханшийн бодит бус зардал гарсан нь ашгийн төлөвлөгөө буурахад нөлөөллөө. Валютын ханшийн алдагдлыг тооцохгүй бол 18,449.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

ЦЭХ-ний нэгжийн өөрийн өртөг 48.30 төгрөг байгаа ба 1 кВт.ц ЦЭХ-ийг дунджаар 69.63 төгрөгөөр борлуулж, нэгжээс 21.33 төгрөгийн, нийт ЦЭХ-ний үйлдвэрлэлтээс 38,537.0 сая төгрөгийн ашигтай ажилласан.

ДЭХ-ний нэгжийн өөрийн өртөг 23,616.04 төгрөг байгаа ба 1 Гкал ДЭХ-ийг дунджаар 13,158.26 төгрөгөөр борлуулсан нь нэгжээс 10,457.77 төгрөгийн, нийт ДЭХ үйлдвэрлэлтээс 21,899.53 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### *Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал*

Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал 0.9595 төгрөг гарч төлөвлөсөн хэмжээнээс 0.011 төгрөгөөр өссөн байна.

### **Цалингийн сангийн зарцуулалт**

2020 оны эхний хагас жилд 20,969.9 сая төгрөг төлөвлөн 20,963.5 сая төгрөг зарцуулсан. 2020 оны эхний хагас жилийн байдлаар 6.4 сая төгрөгний хэмнэлттэй байна.



Компанийн хэмжээнд 2020 оны эхний хагас жилийн байдлаар дундаж цалин хөлс 2,373,050 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 187,235 төгрөг буюу 8.6%-аар өссөн байна. Дансны дундаж хүний тоо 1472 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 18 хүнээр буурсан.

Сарын ажлын үр дүнгээр олгох урамшууллыг эхний хагас жилд 47%-иар төлөвлөж, гүйцэтгэлээр 45%-иар урамшуулал олгогдон 145.2 сая төгрөгөөр сарын үр дүнгийн урамшуулал хэмнэсэн. 2019 оны 12 дугаар сард үйлдвэрлэлийн осол гарч “осол авааргүй ажилласанд” үзүүлэлтийн 10% хасагдсан нь үр дүнгийн урамшуулал хэмнэгдэхэд нөлөөлсөн.

Компанийн цалин хөлсний сангаас тахир дутуу хөгжлийн бэрхшээлтэй буюу тохижолт үйлчилгээний үйлчлэгч 24 ажилтныг цалинжуулж ажиллалаа.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

2020 оны 6-р сарын 30-ны байдлаар тус компани нь 56,351.5 сая төгрөгийн эргэлтийн, 940,279.6 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй, 47,507.5 сая төгрөгийн богино хугацаат, 468,365.0 сая төгрөгийн урт хугацаат өрттэй, 480,758.6 сая төгрөгийн эзэмшигчдийн өмчтэй нийтдээ 996,631.1 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Нийт мөнгөн орлого, зарлагын урсгалыг авч үзвэл:

сая төгрөгөөр

Үзүүлэлтүүд		2019.06.30		2020.06.30		Зөрүү	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Мөнгөний орох урсгал	ДҮТ ТӨХК	104,660.0	57.3	112,850.9	76.2	8,190.9	18.9
	УБДС ТӨХК	20,471.4	11.2	22,298.0	15.0	1,826.6	3.8
	Уурын борлуулалт	2,007.7	1.1	2,248.4	1.5	240.7	0.4
	Өөрийн борлуулалт	957.3	0.5	1,158.3	0.8	201.0	0.3
	Зээл	53,525.6	29.3	4,948.1	3.3	-48,557.5	-309.0
	Бусад	1,020.3	0.6	4,683.6	3.2	3,663.3	2.6
	<b>Нийт орох урсгал</b>	<b>182,642.3</b>	<b>100.0</b>	<b>148,187.3</b>	<b>100.0</b>	<b>-34,455.0</b>	<b>0.0</b>
Мөнгөний гарах урсгал	Цалин	19,369.3	10.8	21,407.7	14.9	2,038.4	4.1
	Нүүрс	54,300.2	30.3	57,918.0	40.4	3,617.8	10.1
	Тээврийн хөлс	8,100.0	4.5	7,484.1	5.2	-615.9	0.7
	Сэлбэг хэрэгсэл	17,138.9	9.6	14,604.4	10.2	-2,534.5	0.6
	Их засварын хөлс	4,493.2	2.5	4,851.0	3.4	357.8	0.9
	НДШ	5,320.0	3.0	5,680.0	4.0	360.0	1.0
	НӨАТ	5,600.0	3.1	10,879.8	7.6	5,279.8	4.5
	Бусад татвар	3,673.9	2.1	5,088.9	3.5	1,415.0	1.5
	Зээл, зээлийн хүү	9,074.5	5.1	6,246.8	4.4	-2,818.1	-0.7
	Ажилчдын нийгмийн зардал	1,580.9	0.9	1,920.5	1.3	339.6	0.5
	ТА 1-4 төсөл	48,438.5	27.0	4,948.1	3.5	-43,500.0	-23.6
	Бусад	1,995.7	1.1	2,358.1	1.6	362.4	0.5
	<b>Нийт гарах урсгал</b>	<b>179,085.1</b>	<b>100.0</b>	<b>143,387.4</b>	<b>100.0</b>	<b>-35,697.7</b>	<b>0.0</b>

2020 оны 2-р улирлын байдлаар касс болон харилцах дансанд нийтдээ 148,187.3 сая төгрөг төвлөрсөн нь өнгөрсөн оныхоос 34,455.0 сая төгрөгөөр буурсан. Энэ нь өнгөрсөн оны мөн үед ТА 1-4 шинэчлэлийн төсөлд 48,525.6 сая төгрөгийн зээл, эргэлтийн хөрөнгийн 5 тэрбум төгрөгийн зээлийг капитрон банкнаас авч байсан нь нөлөөлсөн байна.

Нийт орлогын 76.2% буюу 112,850.9 сая төгрөгийг ДҮТ ТӨХК-иас, 15.0% буюу 22,298.0 сая төгрөгийг УБДС ТӨХК-иас төвлөрсөн байна.

Арилжааны банкуудаас дансны дундаж үлдэгдэлд олгосон хүүгийн орлогод 69.8 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлогыг олсон.

2-р улирлын байдлаар 200 орчим байгууллагад 143,387.4 сая төгрөгийн төлбөр хийлээ. Мөнгөний хуваарилалтыг авч үзвэл нийт зарцуулалтын 40.4% буюу 57,918.0 сая төгрөгийг нүүрсэнд, 14.9% буюу 21,407.7 сая төгрөгийг цалинд, 10.2% буюу 14,604.4 сая төгрөгийг сэлбэг материалын үнэнд, 5.2% буюу 7,484.1 сая төгрөгийг тээврийн хөлсэнд, 3.5% буюу 4,948.1 сая төгрөгийг ТА-2,3 шинэчлэлд тус тус төлжээ.

Төсөвт төлөх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн дагуу цаг тухайд нь төлж ирлээ. Татвар төлөлтийг урд оны мөн үетэй харьцуулж үзвэл:

сая төгрөгөөр

№	Татварын төрөл	2019.06.30	2020.06.30
1	ААНОАТ	593.1	1,488.3
2	НӨАТ	мөнгөөр	7,336.1
		хаалтаар	1,989.2
3	НДШ	5,320.0	5,680.0
4	ХХОАТатварт	2,282.8	2,544.6
5	ҮХХ-ийн татварт	410.5	597.8
6	Газрын татварт	29.7	192.7
7	Усны нөөц ашигласны төлбөр	257.8	265.4
<b>НИЙТ ДҮН</b>		<b>16,876.1</b>	<b>20,094.1</b>

2020 оны 2-р улирлын байдлаар 20,094.1 сая төгрөгийн татвар, шимтгэлийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 3,218.0 сая төгрөгөөр өссөн байна.

Материалын талаар:

Бараа материалын үлдэгдлийг нэр төрөл тус бүрээр нь авч үзвэл:

сая төгрөгөөр

Төрөл	2019.06.30	2020.06.30	Зөрүү
Нүүрс	4,696.5	4,064.4	-632.1
Мазут	2,180.3	2,510.9	330.6
Үндсэн сэлбэг хэрэгсэл	9,645.9	13,205.8	3,559.9
Хангамжийн материал	236.1	234.2	-1.9
Шатахуун тосолгооны материал	686.4	332.7	-353.7
Тээвэр машин механизмын сэлбэг	69.7	45.5	-24.2
Химийн сэлбэг	485.9	522.8	36.9
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	261.6	329.2	67.6
Бусад бараа	184.3	106.9	-77.4
<b>НИЙТ ДҮН</b>	<b>18,446.7</b>	<b>21,352.4</b>	<b>2,905.7</b>

Материалын үлдэгдэл 21,352.4 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 2,905.7 сая төгрөгөөр өссөн байна. Мазутын үлдэгдэл 330.6 сая төгрөгөөр, үндсэн сэлбэг материал 3,559.9 сая төгрөгөөр, химийн материал 36.9 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 67.6 сая төгрөгөөр тус тус өсч, үндсэн түүхий эд материал нүүрс 632.1 сая төгрөгөөр, тээвэр машин механизмын сэлбэг 24.2 сая төгрөгөөр, хангамжийн материал 1.9 сая төгрөгөөр, шатахуун тосолгооны материал 353.7 сая төгрөгөөр, бусад бараа 77.4 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын үлдэгдэл



2020 оны 2-р улирлын байдлаар 1,727.9 мянган тонн нүүрс хүлээн авч 1,793.1 мянган тонныг зарцуулж 100.8 мянган тонн нүүрс талбай дээр үлдсэн нь өнгөрсөн оны үлдэгдлээс биет хэмжээгээр 22.3 мянган тонноор буурсан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг авч үзвэл:

сая төгрөгөөр

Хөрөнгийн төрөл	2019.06.30		2020.06.30		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх %	Дүн	Эзлэх %	Дүн	Эзлэх %
Газрын сайжруулалт	2,123.0	0.2	2,264.6	0.2	141.6	0.0
Барилга байгууламж	147,499.5	11.7	148,803.9	11.1	1,304.4	-0.6
Машин тоног төхөөрөмж	986,794.7	78.1	1,030,109.2	76.8	43,314.5	-1.3
Тээврийн хэрэгсэл	7,480.3	0.6	10,786.7	0.8	3,306.4	0.2
Тавилга эд хогшил	1,598.8	0.1	2,424.2	0.2	825.4	0.1
Компьютер бусад хэрэгсэл	1,504.5	0.1	2,104.7	0.2	600.2	0.0
Бусад үндсэн хөрөнгө	67,003.0	5.3	94,650.4	7.1	27,647.4	1.8
Биет бус хөрөнгө	2,277.4	0.2	2,120.5	0.2	-156.9	0.0
Газар эзэмших эрх	47,617.2	3.8	47,617.2	3.6	-	-0.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,263,898.4</b>	<b>100.0</b>	<b>1,340,881.4</b>	<b>100.0</b>	<b>76,983.0</b>	<b>0.0</b>
Хуримтлагдсан элэгдэл	697,774.0	55.2	640,708.3	47.8	-57,065.7	-7.4
Үлдэгдэл өртөг	566,124.4	44.8	700,173.1	52.2	134,048.7	7.4

Үндсэн хөрөнгийн дансны үнэ оны эхнээс 134,048.7 сая төгрөгөөр өсч 700,173.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй боллоо.

2020 оны 2-р улирлын байдлаарх үндсэн хөрөнгийн өөрчлөлтийг үзүүлбэл:

сая төгрөгөөр

Гүйлгээний утга		Анхны өртөг	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
<b>2020.01.01-ний үлдэгдэл</b>		<b>1,334,937.9</b>	<b>615,408.6</b>	<b>719,529.3</b>
Нэмэгдсэн	Худалдаж авсан	2,083.4		
	Үнэ төлбөргүй авсан	16.9		
	Капиталжуулсан	3,843.1		
	Залруулсан			
Хасагдсан	Үнэгүй шилжүүлсэн			
	Акталсан			
	Залруулсан			
2020 онд байгуулсан элэгдэл			25,299.6	
<b>2020.06.30-ны үлдэгдэл</b>		<b>1,340,881.3</b>	<b>640,708.2</b>	<b>700,173.1</b>

2-р улирлын байдлаар үндсэн хөрөнгийн үлдэх өртөг 719,529.2 сая төгрөгөөс 700,173.1 сая төгрөг болж 19,356.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Бууралтанд үзүүлсэн нөлөөллийг авч үзвэл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 15 нэрийн 2,083.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 3,843.1 сая төгрөгийн их засварын ажлын гүйцэтгэлийг капиталжуулалтаар бүртгэж, мөн ТӨБЗГ-н 2020 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 41 тоот тогтоолоор ДЦС-3 ТӨХК-с хүчилтөрөгчийн хуучин тоноглолыг 16.9 сая төгрөгөөр балансаас балансаас шилжүүлэн авсан нь үндсэн хөрөнгийг 5,943.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн ба тайлант хугацаанд 25,299.5 сая төгрөгийн элэгдэл хорогдлийн шимтгэл байгуулсан нь 19,356.1 сая төгрөгийн бууралтыг бий болгосон байна.



2019 оноос дамжин хийгдсэн Хурц уурын коллекторын III секцийн шугамын их засварын ажил дууссан тул үндсэн хөрөнгөд 1,571.7 сая төгрөгөөр бүртгэлд тусгасан.

Биет болон биет бус хөрөнгийг 26 дансанд хуримтлуулан бүртгэж байна. Үндсэн хөрөнгөд байгуулах элэгдэл хорогдлийн шимтгэлийг тооцохдоо Гүйцэтгэх захирлын 2017 оны А/143 тоот тушаалын хавсралтанд дурдсан ашиглах жилийн хугацааг мөрдөж байна.

Үйлдвэрлэлийн гол тоног төхөөрөмж болох зуух, турбин, цахилгаан, түлш, ус боловсруулах системийн тоног төхөөрөмжийн үлдэх өртөг тайлант оны эхэнд 496,695.4 сая төгрөг байгаа нь үндсэн хөрөнгийн 69.0%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд уг тоног төхөөрөмжинд тайлант хугацаанд 19,718.2 сая төгрөгийн элэгдэл хорогдлийн шимтгэл байгуулсан нь нийт элэгдлийн зардлын 78.0% нь байна.

Тайлант хугацаанд 25,299.5 сая төгрөгийн элэгдэл хорогдлын шимтгэлийн 19,718.2 сая төгрөг буюу 78.0% нь үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмж, 2,824.7 сая төгрөг буюу 11.2% нь барилга байгууламж, 2,101.1 сая төгрөг буюу 8.3% нь үйлдвэрлэлийн бусад тоног төхөөрөмж, 0.65 сая төгрөг буюу 2.5% нь тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер түүний дагалдах хэрэгсэл, программ хангамжид тус тус байгуулсан байна.

Дуусаагүй барилгын дансанд 240,106.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Д/д	Дуусаагүй ажлын нэр	Дүн /сая төгрөг/	Тайлбар
1	МОН Р10 төслийн ажил	63,254.3	Төслийн ажил дуусаагүй
2	ТА 1-4 шинэчлэл төсөл	173,260.3	Төслийн ажил дуусаагүй
3	Бусад	3,591.9	Дуусаагүй ажил

Өр, авлагын талаар:

Авлагын үлдэгдлийг төрөл тус бүрээр нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал:

сая төгрөгөөр

Авлагын төрөл	2019.06.30	2020.06.30	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
<b>ДҮТ ХХК</b>	16,142.3	24,693.1	8,550.8	53.0
Уурын авлага	315.1	263.9	-51.2	-16.2
Жижиг хэрэглэгч	46.9	24.2	-22.7	-48.4
Байгууллагаас авах авлага	408.5	425.3	16.8	4.1
Хувь хүмүүсээс авах авлага	14.0	13.8	-0.2	-1.4
Бусад авлага	40.3	24.9	-15.4	-38.2
<b>Нийт авлага</b>	<b>16,967.1</b>	<b>25,445.2</b>	<b>8,478.1</b>	<b>50.0</b>
Найдваргүй авлагын нөөц	979.0	1,763.3	784.3	80.1
<b>Цэвэр авлагын дүн</b>	<b>15,988.1</b>	<b>23,681.9</b>	<b>7,693.8</b>	<b>48.1</b>

ДҮТ ХХК-иас авах авлагын дүн 24,693.1 сая төгрөгт хүрч оны эхнээс үеэс 6,105.4 сая төгрөгөөр өссөн.

2-р улирлын байдлаар ДҮТ ХХК-д НӨТ-тэй дүнгээр 133,743.6 сая төгрөгний ЦЭХ-ийг борлуулсан байна. ДҮТ ХХК нь 127,638.2 сая төгрөгний төлбөр хийж борлуулалтын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөг 95.4%-иар биелүүлсэн. Нийт төлбөрийн 88.4% буюу 112,850.9 сая төгрөгийг харилцах дансанд мөнгөөр, 11.6% буюу 14,787.3 сая төгрөгийг хоорондын тооцооны хаалтаар хийсэн байна.

УБДС ТӨХК нь борлуулалтын орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллаж байна. 2-р улирлын байдлаар УБДС ТӨХК-д НӨТ-тэй 26,487.7 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөг 104,1%-иар биелүүлж, авлагыг 1,095.2 сая төгрөгөөр бууруулсан. Нийт төлбөрийн 80.7% буюу 22,298.0 сая төгрөгийг харилцах дансанд мөнгөөр, 19.3% буюу 5,323.3 сая төгрөгийг хоорондын тооцооны хаалтаар хийлээ.

Богино хугацаат өглөгийг төрөл тус бүрээр нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал:

сая төгрөгөөр

Төрөл	2019.06.30	2020.06.30	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Дансны өглөг	8,638.0	5,454.3	-3,183.7	-36.9
Татвар НДШ-ийн өглөг	516.8	9.9	-506.9	-98.1
УХЗээлийн тайлант үеийн өр	7,912.3	29,388.5	21,476.2	0.0
Хүүгийн өглөг	711.6	6,652.1	5,940.5	0.0
Нөөц өр төлбөр	377.4	726.5	349.1	92.5
Урьдчилж орсон орлого	4,658.2	5,113.2	455.0	9.8
Бусад	139.7	162.9	23.2	0.0
<b>Нийт өглөг</b>	<b>22,954.0</b>	<b>47,507.4</b>	<b>24,553.4</b>	<b>107.0</b>

Богино хугацаат өглөг өмнөх оны мөн үеэс 24,553.4 сая төгрөгөөр өссөн. Үүнд урт хугацаат зээлийн тайлант үеийн өглөг, урьдчилж орсон орлогын үлдэгдлийг урт хугацаатаас богино хугацаат руу шилжүүлсэн, Турбоагрегат -1, 2, 3-ын үндсэн төлбөрийг 2020 оноос төлж эхэлж байгаа нь, ажиллагсадын тэтгэвэр тэтгэмжийн сангийн тооцоог хагас жилийн байдлаар дахин тооцоолсон нь тус тус нөлөөлсөн.

Багануурын уурхайн нүүрсний төлбөр, төмөр замын тээврийн хөлс, засварын ажлын хөлс, тендерийн сэлбэг материал, татвар нийгмийн даатгал бусад төлбөр тооцоонуудыг гэрээний болон хуулийн хугацаанд барагдуулж үлдэгдлийг бууруулахад гол анхаарлаа хандуулж ажиллалаа.

Нийт 9 зээл хэрэгжиж байна. Дамжуулан зээлдүүлэх төслийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг графикийн дагуу бүрэн төлсөн.

Зээлийн тооцоог төсөл тус бүрээр авч үзвэл:

сая төгрөгөөр

Зээл олгогч	Зээлийн зориулалт	Эхний үлдэгдэл 2020.01.01	Төлөлт		Эцсийн үлдэгдэл 2020.06.30
			Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	
Сангийн яам	Зуухны шинэчлэл MON P3	3,857.8	1,285.9	253.9	2,571.8
Сангийн яам	Зуухны шинэчлэл MON P6	38,687.8	1,172.3	505.2	37,515.5
УБДС ТӨХК	ДҮАТ -1548	5,170.9	206.8	62.5	4,964.1
УБДС ТӨХК	ЭХХТ-1492	1.5	0.0	0.3	1.5
ЦДҮС ТӨХК	ЭХХ-1	230.4	230.4	1.4	0.0
Сангийн яам	ЭХҮАшиг II	20,225.4	0.0	505.6	20,225.4
Хөгжлийн банк	Хүчин чадал 123МВт- р нэмэгдүүлэх 3-ДС- ХО 2015-74/1	8,830.3	2,228.4	297.3	6,839.5
Хөгжлийн банк	ТА 1-4 шинэчлэх ЗГ- ДЦС-3 2018-19	168,265.2	0.0	3,489.3	179,438.4
Сангийн яам	MON P10	42,693.2	0.0	2,336.5	110,610.8
<b>Нийт дүн</b>		<b>287,962.4</b>	<b>5,123.8</b>	<b>7,452.0</b>	<b>362,167.0</b>

2020 оны 2-р улирлын байдлаар үндсэн төлбөрт 5,123.8 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 7,452.0 сая төгрөгийг төлсөн.

**Дүгнэлт:**

1. Тайлант хугацаанд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлтийг 100.8% буюу 16.2 сая кВтц-аар, цахилгаан эрчим хүчний түгээлтийг 101.2% буюу 22.2 сая кВтц-аар давуулан биелүүлж, дулааны эрчим хүчний түгээлтийг 99.9% буюу 1.9 мянган Гкал-аар дутуу түгээсэн. Дотоод хэрэгцээний ЦЭХ-ийг 0.40 нэгж хувиар хэмнэсэн.
2. Тайлант хугацаанд 153,372.1 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж өмнөх оны мөн үеэс 13,589.4 сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс 1,806.7 сая төгрөгөөр тус тус өссөн. Энэ нь цахилгаан эрчим хүчний түгээлт давсантай холбоотой.
3. Нийт 157,472.7 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөөг 100.97 хувиар биелүүлж орлого төлөвлөвлөснөөс 1,519.9 сая төгрөгөөр өссөн
4. 2020 оны эхний хагас жилд 6,379.6 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллаж, ашиг төлөвлөснөөс 1,660.6 сая төгрөгөөр буурсан. Ашгийн бууралтад 2,069.8 сая төгрөгийн валютын ханшийн бодит бус алдагдал гарсан нөлөөллөө.
5. Борлуулсан бүтээгдэхүүний орлого цуглуулалт 96.92% байгаа ба НХАЗ-аас орлого дутуу төвлөрч “ДҮТ” ХХК-аас авах авлага 6,105.4 сая төгрөгөөр өсөж 24,693.1 сая төгрөг болсон байна.
6. Цахилгаан эрчим хүчний өөрийн өртгийг төлөвлөснөөс 3.04 төгрөгөөр, дулааны эрчим хүчний өөрийн өртгийг 1,157.58 төгрөгөөр тус тус бууруулж техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хангаж ажилласан.
7. 2-р улирлын байдлаар бараа материалын үлдэгдэл 21,352.4 сая төгрөг болж оны эхнээс 2,318.1 сая төгрөгөөр өссөн. Тайлант хугацаанд нийт 10,450.1 сая төгрөгийн сэлбэг материал худалдаж авснаас 6,493.7 сая төгрөгийн материалыг зарцуулж 3,956.3 сая төгрөгийн сэлбэг материал худалдан авалтаас үлдсэн байна. Тайлант хугацааны худалдан авалтаас үлдсэн материалын 2,030.1 сая төгрөг нь MON P10 төслийн шугамаар хүлээн авсан материал юм.
8. Тайлант хугацаанд нийт авлага 25,445.1 сая төгрөг болж оны эхнээс 5,057.3 сая төгрөгөөр өссөн. Авлагын 97.1%-ийг эрчим хүчний борлуулалтын авлага, 1.1%-ийг үйлдвэрлэлийн байгууллагаас авах авлага, 1.8%-ийг бусад авлага эзэлж байна. Оны эхэнтэй харьцуулбал нийт авлага 5,057.4 сая төгрөгөөр өссөн нь “Нэг худалдан авагчаас авах авлага” 6,105.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.
9. Нийт өр төлбөр оны эхнээс 4,427.2 сая төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 24,553.4 сая төгрөгөөр өссөн. Нийт өр төлбөрийн 75.9%-ийг зээлийн хүүгийн өглөг, 11.9%-ийг бусад өглөг, 10.8%-ийг эрчим хүчний борлуулалтын өглөг эзэлж байна. Нүүрсний уурхайнуудын өглөг 689.3 сая байгаа нь оны эхнээс 865.9 сая төгрөгөөр өмнөх оны мөн үеэс 79.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна.